

Сайн мэдээг заах ба судлах үндэс

Шашны семинар ба институтийн зорилго

Бидний зорилго нь өсвөр үеийнхэн болон залуучуудыг Есүс Христийн сургаал ба Цагаатгалыг ойлгон, үүнд найдаж, Ариун сүмийн адислалуудыг хүлээн авахад зохистой байж, өөрсдийгөө болон гэр бүлээ түүнчлэн бусдыг Тэнгэр дэх Эцэгтэйгээ хамт байх мөнхийн амьдралд бэлтгэхэд нь туслахад оршдог.

Заах

1. Бид суралцагсад сайн мэдээний сургаал ба зарчмуудыг бошиглогчдын үгс болон судрууд дээр байгаагаар нь заадаг.
2. Энэхүү сургаал болон зарчмуудыг ойлгож, сэнхрэхэд нь чиглүүлэн заадаг.
3. Бид суралцагсад суралцах явцдаа өөрсдийн үүргээ биелүүлэхэд нь тусалдаг ба сайн мэдээг бусдад заахад бэлтгэдэг.

Эдгээр зорилгод хүрэхийн тулд семинар, институтийн багш суралцагсдыг сайн мэдээг заах ба судлах үндсийг амьдралдаа хэрэгжүүлэхийг дэмжих ёстой.

Багш, суралцагсад нь:

- Сүнсээр зааж, Сүнсээр суралцах ёстой.
- Хайр, хүндэтгэл болон зорилго агуулсан суралцах орчинг бүрдүүлэх хэрэгтэй.
- Судраас өдөр бүр суралцаж, хичээлийн материалыг унших ёстой.
- Судруудын болон бошиглогчдын үгсийн түүх, агуулгыг ойлгох ёстой.
- Сайн мэдээний сургаал ба зарчмуудын үнэн болоод чухал ач холбогдлыг ойлгож, танин мэдэрч, амьдралдаа хэрэгжүүлэх ёстой.
- Сайн мэдээний сургаал ба зарчмуудыг тайлбарлах, хуваалцах мөн гэрчлэх хэрэгтэй.

- Төгс эзэмших судрын хэсгүүд болон үндсэн сургаалуудыг төгс эзэмших хэрэгтэй.

Эдгээр зарчим, дадлага ба үр дүнгүүд нь хоорондоо холбогддог. Эдгээрийг ухаалгаар нэг нэгэнтэй нь уялдуулан хэрэгжүүлэхэд, суралцагсдын судруудыг болон судруудад агуулагддаг зарчим, сургаалуудыг ойлгох чадварыг нэмэгдүүлдэг. Эдгээр нь суралцагсдыг сайн мэдээг судлахад урамшуулж, тэдний сайн мэдээний дагуу амьдрах мөн үүнийг бусдад заах чадварыг нэмэгдүүлдэг.

ЕСҮС ХРИСТИЙН
ХОЖМЫН ҮЕИЙН
ГЭГЭЭНТНҮҮДИЙН СҮМ